



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-НИЙ 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/09/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 260512 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn  
Ахлах аудитор: В.Эрдэнэцогт  
Утас: 261628 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn  
“Мэдээлэл Аудит” ХХК-ийн Захирал Д.Товуудорж  
Утас: 70159511, 99049511 Цахим хаяг: medeelaudit@gmail.com

Улаанбаатар хот  
2024 он

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**АГУУЛГА**

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Албан шаардлага .....	17
5.2 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	19
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
ДЭХ	Дулааны эрчим хүч
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УБТЗ ХНН	Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦДҮС	Цахилгаан түгээх үндэсний сүлжээ



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15110 Улаанбаатар хот Чингэлтэл дүүрэг  
Тала тоируу 3 Засгийн газрын IV байр  
Утас 26-04-37, Факс 51 26-42 30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.26

№

07 470

танай

ны №

т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус компани 1998-2017 оны хооронд эрчим хүчийг сэргээн засварлах, дулааны үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчийг хэмнэх зорилгоор Азийн хөгжлийн банк, Нордикийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжсэн 6 төсөл, хөтөлбөрийн хүрээнд бий болсон төсөл, арга хэмжээний урт хугацаат өр төлбөрийн 10,527.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Аудитын гол асуудал

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 637 дугаар тогтоолын дагуу цахилгаан эрчим хүчний худалдах дундаж үнэ 140.94 төгрөг байсныг 146.67 төгрөг болгож, 5.73 төгрөгөөр буюу 4.0 хувиар нэмэгдүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 156 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,642,351,256.41	2,457,951,231.92
1.1.02	Дансны авлага	9,584,244,437.73	5,865,105,592.45
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	1,618,654,954.48	1,857,735,991.89
1.1.04	Бусад авлага	33,532,231.53	16,163,952.10
1.1.06	Бараа материал	12,016,683,194.19	15,457,864,719.85
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,502,672,360.35	309,909,867.72
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	333,184,975.60	204,765,158.10
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>28,731,323,410.29</b>	<b>26,169,496,514.03</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	220,619,612,021.98	214,330,934,999.70
1.2.02	Биет бус хөрөнгө	39,123,754,352.53	39,583,821,470.44
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>259,743,366,374.51</b>	<b>253,914,756,470.14</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>288,474,689,784.80</b>	<b>280,084,252,984.17</b>
2.1.1.01	Дансны өглөг	5,416,571,188.48	3,951,361,824.38
2.1.1.02	Цалингийн өглөг	4,042,575,958.73	4,275,617.28
2.1.1.03	Татварын өр	0.00	268,253,066.32
2.1.1.05	Богино хугацаат зээл	1,778,140,806.52	1,778,140,806.52
2.1.1.06	Хүүний өглөг	141,491,696.21	136,865,649.74
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	98,892,548.32	43,533,373.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	112,144,099.73	100,375,332.54
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>11,589,816,297.99</b>	<b>6,282,805,669.78</b>
2.1.2.01	Урт хугацаат зээл	11,710,865,933.37	9,932,725,126.85
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	1,359,339,776.78	1,028,571,501.06
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	1,989,965,201.34	1,613,970,638.49
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>15,060,170,911.49</b>	<b>12,575,267,266.40</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>26,649,987,209.48</b>	<b>18,858,072,936.18</b>
2.3.01	Өмч: - төрийн	99,362,782,973.56	99,362,782,973.56
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	157,971,926,506.86	157,760,921,987.30
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	38,922,250,000.00	39,454,300,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(34,432,256,905.10)	(35,351,824,912.87)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	(1,130,572,527.33)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(34,432,256,905.10)	(34,221,252,385.54)
2.3.11	Эздийн өмчийн дүн	261,824,702,575.32	261,226,180,047.99
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>288,474,689,784.80</b>	<b>280,084,252,984.17</b>

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	131,465,185,913.68	162,548,726,483.20
2	Борлуулалтын өртөг	125,961,233,517.27	148,991,693,705.58
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>5,503,952,396.41</b>	<b>13,557,032,777.62</b>
4	Түрээсийн орлого	76,583,876.85	69,501,638.83
5	Хүүний орлого		221,969,030.82
8	Бусад орлого	645,452,560.31	643,698,019.42
8.1	Орлогын дүн	722,036,437.16	935,168,689.07
9	Борлуулалт, маркетингийн зардал	288,804,752.53	263,710,899.59
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,846,025,427.70	9,514,067,581.19
11	Санхүүгийн зардал	287,049,993.57	252,049,694.81
12	Бусад зардал	1,944,965,492.54	4,061,457,498.20
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4,906,827.82	(279,171.63)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,344,962,301.50)	(1,509,012,245.50)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(6,480,912,306.45)</b>	<b>(1,108,375,624.23)</b>
19	Орлогын татварын зардал		22,196,903.10
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(6,480,912,306.45)</b>	<b>(1,130,572,527.33)</b>
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(6,480,912,306.45)</b>	<b>(1,130,572,527.33)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	99,362,782,973.56	157,971,926,506.86	38,753,450,000.00	(27,560,196,266.47)	268,527,963,213.95
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(379,148,332.18)	(379,148,332.18)
Залруулсан үлдэгдэл	99,362,782,973.56	157,971,926,506.86	38,753,450,000.00	(27,939,344,598.65)	268,148,814,881.77
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(6,480,912,306.45)	(6,480,912,306.45)
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт			168,800,000.00		168,800,000.00
Зарласан ногдол ашиг				(12,000,000.00)	(12,000,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	99,362,782,973.56	157,971,926,506.86	38,922,250,000.00	(34,432,256,905.10)	261,824,702,575.32
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				211,004,519.56	211,004,519.56
Залруулсан үлдэгдэл	99,362,782,973.56	157,971,926,506.86	38,922,250,000.00	(34,221,252,385.54)	262,035,707,094.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,130,572,527.33)	(1,130,572,527.33)
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт			532,050,000.00		532,050,000.00
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(211,004,519.56)			(211,004,519.56)
2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	99,362,782,973.56	157,760,921,987.30	39,454,300,000.00	(35,351,824,912.87)	261,226,180,047.99



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Мөрийн дугаар	Балансын зүйл	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>141,072,578,908.34</b>	<b>173,234,087,469.29</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	140,532,366,457.57	172,671,404,526.74
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	185,270,102.00	204,362,344.50
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	354,942,348.77	358,320,598.05
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>127,538,069,758.33</b>	<b>162,683,656,104.15</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	25,881,239,670.02	33,263,902,681.89
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,453,000,000.00	10,266,100,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	68,476,752,407.30	87,657,855,879.36
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,803,259,756.56	1,870,360,387.15
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,694,502,408.21	16,674,732,140.56
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	55,634,358.30	51,435,944.77
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	7,733,195,931.07	9,598,631,710.24
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	55,105,890.00	59,560,990.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,385,379,336.87	3,241,076,370.18
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>13,534,509,150.01</b>	<b>10,550,431,365.14</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>221,966,724.48</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		221,966,724.48
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8	Бусад		
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>12,416,818,707.01</b>	<b>11,743,382,914.79</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,416,818,707.01	11,742,172,914.79
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,210,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6	Бусад		
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(12,416,818,707.01)</b>	<b>(11,521,416,190.31)</b>
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад		
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>225,415,199.33</b>	<b>213,415,199.32</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	213,415,199.33	213,415,199.32
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	12,000,000.00	
3.2.5	Бусад		
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(225,415,199.33)</b>	<b>(213,415,199.32)</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>892,275,243.67</b>	<b>(1,184,400,024.49)</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,750,076,012.74</b>	<b>3,642,351,256.41</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,642,351,256.41</b>	<b>2,457,951,231.92</b>

**"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл	2023 он		Өөрчлөлт /өссөн +, буурсан -/	
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Боловсруулсан	Цахилгаан эрчим хүч	мян.кВтц	1,085,787.9	1,106,328.0	1,132,330.8	26,002.8	2.4
	ДХЦЭХ	хувиар	хувь	16.9	17.1	16.6	(0.5)	(2.9)
		биетээр	мян.кВтц	183,248.2	189,229.0	187,999.0	(1,230.0)	(0.6)
	Эрчим хүчний түгээлт	ЦЭХ	мян.кВтц	902,539.8	917,099.0	944,331.8	27,232.8	3.0
		ДЭХ	Гкал	2,605,683.0	2,393,318.0	2,527,955.0	134,637.0	5.6
	Үнийн дүнгээр	ЦЭХ	мян.төг	96,958,186.9	129,259,643.7	138,501,679.3	9,242,035.5	7.1
ДЭХ		мян.төг	34,506,999.0	23,387,656.3	24,047,047.2	659,390.9	2.8	
2	<b>Нийт орлого</b>		мян.төг	<b>132,192,141.5</b>	<b>153,268,194.8</b>	<b>163,565,826.8</b>	<b>10,297,632.0</b>	<b>6.7</b>
	Үүнээс:	Цэвэр борлуулалт	мян.төг	131,465,185.9	152,647,300.0	162,548,726.5	9,901,426.5	6.5
		Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	726,955.6	620,894.8	1,017,100.3	396,205.6	63.8
3	<b>Нийт зардал</b>		мян.төг	<b>138,673,053.8</b>	<b>165,752,469.2</b>	<b>164,674,202.5</b>	<b>(1,078,266.7)</b>	<b>(0.7)</b>
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	мян.төг	136,799,571.2	163,369,177.7	162,351,009.0	(1,018,168.7)	(0.6)
		Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	1,873,482.5	2,383,291.4	2,323,193.5	(60,098.0)	(2.5)
		Элэгдлийн зардал	мян.төг	23,706,287.6	22,943,532.2	22,903,826.8	(39,705.5)	(0.2)
4	Татварын өмнөх ашиг/алдагдал -/		мян.төг	(6,480,912.3)	(12,484,274.4)	(1,108,375.6)	11,375,898.8	(91.1)
5	Цэвэр ашиг / алдагдал -/		мян.төг	(6,480,912.3)	(12,484,274.4)	(1,130,572.5)	11,353,701.9	(90.9)
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал		мян.төг	1.0	1.1	1.0	(0.1)	(0.9)
7	<b>Нийт авлага</b>		мян.төг	<b>11,236,431.6</b>	<b>12,383,000.0</b>	<b>7,739,005.5</b>	<b>(4,643,994.5)</b>	<b>(37.5)</b>
	Үүнээс:	Эрчим хүчний	мян.төг	9,584,244.4	10,825,000.0	5,865,105.6	(4,959,894.4)	(45.8)
		Бусад	мян.төг	1,652,187.2	1,558,000.0	1,873,899.9	315,899.9	20.3
8	<b>Нийт өглөг</b>		мян.төг	<b>26,649,987.2</b>	<b>26,098,463.5</b>	<b>18,858,072.9</b>	<b>(7,240,390.6)</b>	<b>(27.7)</b>
	Богино хугацаат өр төлбөр		мян.төг	11,589,816.3	13,143,490.8	6,282,805.7	(6,860,685.1)	(52.2)
	Урт хугацаат өр төлбөр		мян.төг	15,060,170.9	12,954,972.7	12,575,267.3	(379,705.5)	(2.9)
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	986.3	1,001.0	977.0	(24.0)	(2.4)
10	Нийт цалингийн сан		мян.төг	32,135,569.1	36,354,484.4	34,362,817.9	(1,991,666.5)	(5.5)
11	Нэг ажиллагчийн дундаж цалин		төг	2,715,079.2	3,026,513.9	2,930,980.7	(95,533.1)	(3.2)
12	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	цахилгаан	гр/кВтц	309.8	313.0	312.9	(0.1)	
		дулаан	кг/Гкал	175.1	175.8	175.8	0.0	
13	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		мян.төг	16,655,156.4	20,651,188.7	18,200,525.2	(2,450,663.5)	(11.9)

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Компани, түүний үйл ажиллагаа**

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн зорилго нь тодорхой үйлчилгээ явуулах нутаг дэвсгэртээ хэрэглэгчийг цахилгаан, дулааны эрчим хүчээр найдвартай хангахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, үйлдвэрлэл эрхэлж, ажил үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчийн хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс 34.0 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, 66.0 хувийг Эрчим хүчний яам эзэмшиж байна.

#### **3.2 Компанийн гадаад, дотоод орчин**

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь үйл ажиллагаандаа дараах эрх зүйн актуудыг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын багц хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын багц хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээр

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн ТУЗ нь тайлант онд 16 удаа хуралдаж, санхүү бүртгэл болон үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалт худалдан авалтын төлөвлөгөөний биелэлт, үүссэн хязгаарлалттай болон тулгамдсан нөхцөл байдлыг шийдвэрлэхээр 22 тогтоолыг хэлэлцэн баталсан байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо 2 удаа хуралдаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг анхааруулж, 2023 оны зорилтот түвшин, их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж зардлыг бууруулах талаар тодорхой асуудлыг хөндсөн 10 зөвлөмж хүргүүлэн ажиллажээ.

Дотоод аудитор тайлант онд төсөв төлөвлөгөө, үйлдвэрлэл, хангамж, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа болон худалдан авалт, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын чиглэлээр хяналтын 12 төрлийн ажлыг төлөвлөж, 100 хувийн биелэлттэй, тайлант онд нийт 27 зөвлөмж өгч, хэрэгжилтийг нь хянаж, тайлагнасан байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК -ний гүйцэтгэх захирлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/384 дүгээр тушаалаар НБББББ-ийн тусгай бодлогыг боловсруулан баталсан байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК -ний 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,390.4 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,642,351.3	2,457,951.2	(1,184,400.0)
Дансны авлага	11,236,431.6	7,739,005.5	(3,497,426.1)
Бараа материал	12,016,683.2	15,457,864.7	3,441,181.5
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,502,672.4	309,909.9	(1,192,762.5)
Бусад эргэлтийн хөрөнгө	333,185.0	204,765.2	(128,419.8)
Үндсэн хөрөнгө	220,619,612.0	214,330,935.0	(6,288,677.0)
Биет бус хөрөнгө	39,123,754.4	39,583,821.5	460,067.1
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>288,474,689.8</b>	<b>280,084,253.0</b>	<b>(8,390,436.8)</b>
Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,589,816.3	6,282,805.7	(5,307,010.6)
Урт хугацаат өр төлбөрийн дүн	15,060,170.9	12,575,267.3	(2,484,903.6)
Эздийн өмчийн дүн	261,824,702.6	261,226,180.0	(598,522.5)
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>288,474,689.8</b>	<b>280,084,253.0</b>	<b>(8,390,436.8)</b>

Авлага дансны үлдэгдэл 7,739.0 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 3,497.4 сая төгрөгөөр буурсан нь харилцагч байгууллагаас авах авлага барагдуулсантай холбоотой байна.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

Авлага дансны үлдэгдэлд ДҮТ ТӨХК-аас авах цахилгаан эрчим хүч борлуулсны 5,420.1 сая төгрөг, УБДС ТӨХК-аас авах дулаан борлуулалтын авлага 113.4 сая төгрөг, ААН байгууллагаас авах уур болон жижиг хэрэглэгчийн цахилгаан дулааны авлага 330.6 сая төгрөг, татварын байгууллагаас авах ХХОАТ, НӨАТ-ын 1,857.7 сая төгрөг, ажилчдаас авах авлага 17.2 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Тайлант онд худалдан авсан бараа материал, сэлбэг хэрэгсэл, материал хангамж 100,222.3 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 96,781.9 сая төгрөгөөр хасагдсан, бараа материалын үлдэгдэл 15,457.8 сая төгрөг болж 3,441.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 1497.7 мянган тонн нүүрс хүлээн авч 1,496.5 мянган тонныг зарцуулан 55.9 мянган тонн нүүрсний үлдэгдэл байгаа нь нөлөөлсөн байна. Мазутын үлдэгдэл 653.2 тонн байна.

Бараа материалын үлдэгдэлд гүйцэтгэх захирлын 2023 оны А/150 дугаар тушаалын дагуу бүрдүүлсэн 171 нэр төрлийн 577.0 сая төгрөгийн аваарын нөөц, мөн 1998-2000 онд “Өндөр даралтын хэсгийн зуухнуудыг шууд үлээлгийн системд шилжүүлэх” төслөөр 4 зуухыг бүрэн шинэчилж, 5 дахь зуухны ажлыг эхлүүлэх үед төслийг зогсоосноос ашиглах боломжгүй 363 нэр төрлийн 1,035.4 сая төгрөгийн зуухны сэлбэг материал байна.

Урьдчилж төлсөн зардлын эхний үлдэгдэлд бүртгэлтэй урьдчилгаа төлбөрөөс тайлант онд хүлээн авсан 1,166.7 сая төгрөгийн нүүрсийг бараа материалд, Улаанбаатар төмөр зам ХХН-ээс авсан ажил үйлчилгээ 530.5 сая төгрөгийг зардалд шилжүүлэн бүртгэсэн дүнгээр буурсан байна. Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгчдэд урьдчилж төлсөн барааны тооцоо 154.3 сая төгрөг, ажиллагсдад олгосон урьдчилгаа 148.7 сая төгрөгийн төлбөр бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгө 1,589.7 сая төгрөг, өргөтгөл, сайжруулалт хийгдсэн үндсэн болон туслах тоноглолын капиталжуулалт 16,550.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2023 оны 10 дугаар тогтоолын дагуу балансаас балансад шилжүүлсэн 115.5 сая төгрөг, Засгийн газрын 2023 оны 289 дугаар тогтоолоор Хан-Уул дүүргийн 16 дугаар хороонд байрлах “Буянт-Ухаа-1” хорооллын 15 айлын орон сууц, 3 дугаар хороонд байрлах “Эрчим” хотхоны 25 айлын орон сууцыг албан хаагчдад үнэ төлбөргүй, 2 айлын орон сууцыг төлбөртэй нөхцөлөөр хувьчлах шийдвэрийн дагуу шилжүүлсэн 1,706.4 сая төгрөгийн хөрөнгө, ТӨБЗГ-ын 2023 оны 480 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн дуудлага худалдаагаар борлуулсан тээврийн хэрэгслийн 22.5 сая төгрөг, акталсан 70 нэр төрлийн хөрөнгө 575.1 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх 3,951.4 сая төгрөгийн өр, цалингийн өр 4.2 сая төгрөг, татварын өр 268.2 сая төгрөг, НББОУС-ын дагуу 2024 онд төлөх зээлийн үндсэн төлбөр болон хойшлогдсон хүүгийн төлбөрт төлөх 1,915.0 сая төгрөгийг богино хугацаат өглөгт шилжүүлэн бүртгэсэн өглөг, урьдчилж орсон орлого 44.5 сая төгрөг, ажиллагсдын хоолны картын 100.3 сая төгрөгийн өр бүртгэлтэй байна.

Урт хугацаат зээлийн үлдэгдэлд 1998-2017 оны хооронд эрчим хүчийг сэргээн засварлах, дулааны үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчний хэмнэх зорилгоор хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд болсон хөрөнгийн Азийн хөгжлийн банкны зээл 7,093.3 сая төгрөг, Нордикийн хөгжлийн сангийн зээл 1,182.3 сая төгрөг, Дулааны үр ашгийн төслийн зээл 2,840.6 сая төгрөг, Эрчим хүчний хэмнэлтийн төслийн зээл 293.8 сая төгрөг, Эрчим хүчний хөтөлбөр-1 төслийн зээл 238.2 сая төгрөг, Эрчим хүчний төслийн зээл 62.6 сая төгрөг, нийт 11,710.9 сая төгрөг байна. Зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөж байгаа хэвийн зээл байна.

Бусад урт хугацаат өр төлбөр дансанд 2014-2017 Чех Улсын Засгийн Газрын буцалтгүй тусламжаар Чехийн Хөгжлийн Агентлаг, ДЦС-3 ТӨХК-ийн хамтран хэрэгжүүлсэн Түлш дамжуулах цехийн тоноглолын удирдлага, хяналтыг шинэчлэх зорилгоор үүссэн 1,613.9 сая төгрөгийн хойшлогдсон орлого бүртгэлтэй байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь үйлдвэрлэл болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 160,120.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 164,493.9 сая төгрөгөөр, 4,373.6 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 20,919.2 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын 2023 оны А/218 дугаар тушаалаар нийт орлогыг 153,268.2 сая, нийт зардлыг 165,752.6 сая төгрөгөөр, алдагдлыг 12,484.3 сая төгрөгөөр тодотгосон байна.

2023 оны анхны төлөвлөгөөнд нийт орлогыг батлахдаа Улаанбаатар хотын цахилгаан, дулаан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2018 оны 309, 2021 оны 146 дугаар тогтоолын дагуу “ДЦС-3” ТӨХК-ийн суурилагдсан хүчин чадлыг 2 үе шаттайгаар шинэчлэн 300 МВт-аар өргөтгөх төслийн ажлын хүрээнд Монголын талын санхүүжилтээр зураг төслийн ажлыг 2023 онд санхүүжүүлэх 7,000.0 сая төгрөгийг бизнес төлөвлөгөөнд тусгасан байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос 2023 оны тарифт уг зураг төслийн санхүүжилтийг суулгаагүй бөгөөд хоёр улсын Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх гэрээ хийгдсэн тохиолдолд тарифт тусгана гэж зөвшилцсөн байна. ОХУ-ын Санкт-Петербург хотноо 2023 оны 6 дугаар сарын 14-17-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Петербургийн олон улсын эдийн засгийн чуулганд Эрчим хүчний сайд тэргүүтэй төлөөлөгчид 2 улсын эрчим хүчний хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд тус төслийн санхүүжилтийн асуудлыг хэлэлцсэн ба 2023 онд санхүүжилт хийгдэхгүй болсныг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн в/2647 тоот албан бичгийг үндэслэн уг зураг төслийн санхүүжилт болох 7,000.0 сая төгрөгийг орлогоос хасаж тодотгосон байна.

Нийт зардлын хувьд УБТЗ-ын даргын 2023 оны 6 дугаар сарын 23-ний өдрийн А-593 тоот тушаалаар төмөр замын тээврийн тарифыг 4.6 хувиар нэмэгдүүлснээр, УБТЗ-ын даргын А-589 тоот тушаалаар вагон ашиглалтын депогийн вагон үзэгч нарын цалинг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үндсэн цалинг 10.0 хувь, гэрээгээр ажиллах сэлгээний ТЭМ-2 илчит тэрэгний 1 цагийн үнэлгээ 21.0 хувь, гэрээгээр ажиллах холбогч, найруулагч, салбар зам арчлалтын хөлс ажилтнуудын цалин 20.0 хувь өссөн болон нүүрсний газар дээрх илчлэгийн нөлөөгөөр түлшний зардлыг 964.0 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Ийнхүү анхны төлөвлөснөөс орлогыг 7,000.0 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 1,226.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, алдагдлын хэмжээг 12,484.3 сая төгрөгөөр тодотгосон байна.

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 102.4 хувиар, түгээлтийн төлөвлөгөөг 103.0 хувиар биелүүлж, Дулааны эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөөг 105.6 хувиар, диспетчерийн графикийг бүрэн биелүүлэн ажилласан байна.

Гүйцэтгэлээр 163,565.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, зардал 164,688.0 сая төгрөгт хүрч, 1,122.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 163,565.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 10,297.6 сая төгрөг буюу 6.3 хувиар давсан нь ЦЭХ, ДЭХ-ний илүү түгээлтээс бүтээгдэхүүний орлого 9,901.4 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус орлого 396.2 сая төгрөгөөр тус тус илүү бүрдсэнтэй холбоотой байна.

Нийт орлого нэмэгдэхэд Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 9 сарын 27-ны өдрийн 580 дугаар тогтоолын тарифын зохицуулалтаар, төмөр замын тээврийн тариф 2023 оны 7 сарын 01-ний өдрөөс нэмэгдсэн, Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 11 сарын 22-ний 637 дугаар тогтоолын тарифын зохицуулалтаар ДЭХ-ний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой түлшний зардал, цалин шимтгэлийн зардлыг 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн түвшинд авчирснаар үнэ тарифын нөлөөгөөр ЦЭХ-ний орлого 7,635.7 сая төгрөгөөр, илүү үйлдвэрлэлтээс 1,628.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. ДЭХ-ний орлогын хувьд УБДС-нд түгээсэн ДЭХ 147.8 мян.Гкалаар давж, төлөвлөснөөс орлого 659.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Тариф нэмэгдсэнээр ЦЭХ-ний орлого 138,327.6 сая төгрөгт хүрч, анхны төлөвлөснөөс 9,067.9 сая төгрөгөөр, ДЭХ-ний орлого 24,071.0 сая төгрөгт хүрч, анхны төлөвлөснөөс 683.4 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн үйл ажиллагааны орлого 163,565.8 сая төгрөгт хүрсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 164,674.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,078.3 сая төгрөг буюу 0.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаад дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

- Түгээлт нэмэгдсэнтэй холбоотой түлшний зардал төлөвлөснөөс 3,821.3 сая төгрөгөөр илүү;
- Тогтмол зардлыг 4,839.5 сая төгрөгөөр, ҮАБЗ-ыг 46.3 сая төгрөгөөр, элэгдлийн зардлыг 39.7 сая төгрөгөөр тус тус дутуу;
- Цалингийн зардалд 34,362.8 сая төгрөг зарцуулж, төлөвлөснөөс 1,991.6 сая төгрөг дутуу нь жилийн үр дүнгийн нэмэгдэл цалинг хойшлуулсантай холбоотой.

Тус станц нь 2023-2024 оны өвлийн бэлтгэл хангах хүрээнд тайлант хугацаанд үндсэн тоноглолын их засварын 7 ажилд 12,616.20 сая төгрөг, туслах тоноглолын их засварын 102 ажилд 2,857.8 сая төгрөг, барилгын их засварын 5 ажилд 971.8 сая төгрөг, ТЗБАХ-ний 7 ажилд 619.54 сая төгрөг, хөрөнгө оруулалтын 35 ажилд 1,144.02 сая төгрөгийг зарцуулж, зорилтот түвшний 13 үзүүлэлтийг бүрэн биелүүлж ажилласан байна.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК -ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани/ТӨХК/, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой худалдан авах тендерийн баримт бичигт захиалагчийн тогтоосон чадавхын шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж байх, НБББББ-ийг шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг өөрсдийн нөөц бололцоогоороо сайжруулалт хийх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мэдээлэл-Аудит ХХК-ийн аудитор Д.Туяа, Ц.Отгонжаргал, Н.Пүрэвсүрэн, С.Адьяахүү нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, захирал Д.Товуудорж нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор В.Эрдэнэцогт, аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар болон Мэдээлэл-Аудит ХХК-д 2024 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 01/224 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүн 137,328.1 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 1,373.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 онд 24 орон тоо дутуу ажиллаж 1,991.6 сая төгрөгийн бодит хэмнэлт гаргасан байна.

##### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг



тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 243.9 сая төгрөгийн асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 243.9 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгасан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөр барагдуулах 1.7 сая төгрөгийн 2 акт, зөрчлийг арилгах 25.4 сая төгрөгийн 3 албан шаардлага, 238.4 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснийг хянахад хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна

*Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Б	1	2	3	4	5	6
1	Акт	2	1,733.6	2	1,733.6	100.0
2	Албан шаардлага	3	25,391.4	3	25,391.4	100.0
3	Зөвлөмж	2	238,426.2	2	238,426.2	100.0
	<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>265,551.2</b>	<b>7</b>	<b>265,551.2</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын үлдэгдэлд 1998-2000 онд "Өндөр даралтын хэсгийн зуухнуудыг шууд үлээлгийн системд шилжүүлэх" төслөөр 4 зуухыг бүрэн шинэчилж, 5 дахь зуухны ажлыг эхлүүлэх үед төслийг зогсоосноос ашиглах боломжгүй байгаа 363 нэр төрлийн 1,035.4 сая төгрөгийн зуухны сэлбэг материалыг эргэлтэд оруулах талаар арга хэмжээ авсан эсэхийг дараагийн аудитаар хамруулна.

Хөдөлмөрийн тухай хуульд Эрчим хүчний салбар дундын хамтын хэлэлцээрийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, компанийн хамтын гэрээг харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллага хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, нийцэж байвал тухайн хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг бүртгэхээр заасан ба Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын анхааралд энэхүү асуудлыг уламжлах нь зүйтэй гэж үзэж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44.4 сая төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

1. Санхүүгийн тайланд өглөгийг 30.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь НБББОУС1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангаагүй;
2. Алданги торгуулийн зардлыг буруутай этгээдээр төлүүлж байгууллагыг хохиролгүй болгосон 13.8 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардлаар тайлагнасан НБББОУС1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдэл хангаагүй.

Аудитаар нийт 532.2 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 472.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 60.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Нийт аудитаар илрүүлсэн 532.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

Турбогенератор №9 их засварт ашиглагдах хаалт, винтель багц-1 худалдан авах 2022 оны 6 дугаар сарын 10-ны 1-3-268/22 дугаар гэрээний дагуу төлбөрийг шилжүүлсэн боловч 105.6 сая төгрөгийн сэлбэг материалыг хүлээн аваагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах" гэсэн заалт, мөн санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний дагуу нийлүүлэх сэлбэг материалыг хүлээн аваагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Тайлант хугацаанд 56 нэр төрлийн 366.5 сая төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгсэл эхний үлдэгдэлтэй байхад нэмэлтээр худалдан авч бэлтгэн, зарцуулаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Үр ашиггүй удаан хадгалах шаардлагагүйгээр бараа материал бэлтгэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгцээ шаардлагад үндэслэн бараа материал бэлтгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

#### 1.1 Илрүүлэлт:

"Таслах, Залгах аппаратын сэлбэг нийлүүлэх" 60.0 сая төгрөгийн өртөгтэй бараа худалдан авах тендерийн баримт бичигт тендерт оролцогч байгууллагын 16.2-т заасан 2021 болон 2022 онд ашигтай ажилласан байх гэсэн шалгуурыг хангаагүй Бэрх өндөр ХХК-ийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 1.2 Өгсөн зөвлөмж:

Хуулийн дагуу захиалагчийн тогтоосон чадавхын шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж байх.

### **НБББББ-тэй холбоотой асуудал**

#### 2.1 Илрүүлэлт:

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн захирлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/384 тушаалаар 2019 оноос эхлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг тухай бүр хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 2.2 Өгсөн зөвлөмж

НБББББ-ийг шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг өөрсдийн нөөц бололцоогоороо сайжруулалт хийх.

Дээрх аудитын шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 2 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Д.Д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
								Тоо	Дүн	Тоо	Дүн			
1	Санхүүгийн тайланд өглөгийг 30.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	30,580.0					1	30,580.0					
2	Алданги торгуулийн зардлыг буруутай этгээдээр төлүүлж байгууллагыг хохиролгүй болгосон 13.8 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардлаар тайлагнасан	1	13,820.6					1	13,820.6					
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>44,400.6</b>					<b>2</b>	<b>44,400.6</b>					

/мянган төгрөгөөр/



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Үүнээс												Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2022 оны 6 сарын 10-ны 1-3-268/22 дугаар гэрээний дагуу Турбогенератор №9 их засварт ашиглагдах хаалт, вентель багц-1 худалдах, худалдан авах гэрээний дагуу мөнгө шилжүүлсэн боловч сэлбэг материалыг хүлээн аваагүй байна.	1	105,681.6			1	105,681.6							
2	56 нэр төрлийн 366.5 сая төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгсэл эхний үлдэгдэлтэй байхад нэмж бэлтгэн, тайлант хугацаанд зарцуулаагүй байна.	1	366,573.2			1	366,573.2							
3	“Таслах, Залгах аппаратын сэлбэг нийлүүлэх” 60.0 сая төгрөгийн өртөгтэй бараа худалдан авах тендерийн баримт бичигт тендерт оролцогч байгууллагын 16.2-т заасан 2021 болон 2022 онд ашигтай ажилласан байх гэсэн шалгуурыг хангаагүй Бэрх өндөр ХХК-ийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан.	1	60,000.0					1	60,000.0					
4	Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн захирлын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/384 тушаалаар 2019 оноос эхлэн	1												

/мянган төгрөгөөр/

**"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг тухай бүр хийгээгүй байна.	4	532,254.8	-	2	472,254.8	2	60,000.0	-	-	-
<b>Дүн</b>										

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага					
			Тоо	Дүн	Тоо	Дүн				
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>										
Хамтын гэрээний 1.5-д "Үндсэн ажлаасаа чөлөөлөгдсөн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга, ажилтныг өөрийн байгууллагын ажилтны нэгэн адил хамтын гэрээнд хамруулан жилийн болон сарын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, тэтгвэрт гарахад нь тэтгэмж олгох бөгөөд олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа хүмүүсийг төр, засгийн шагналд тодорхойлж болно" гэсэн заалтыг үндэслэн орон тооны бус үйлдвэрчний эвлэлийн даргад үр дүнгийн урамшуулал сар болгон олгосон байна.	1								1	
<b>Нийт дүн</b>	<b>1</b>								<b>1</b>	





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 № 527/АОМ0055

Улаанбаатар хот

МАТ-2024/19/АА-ӨА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Турбогенератор №9 их засварт ашиглагдах хаалт, винтель багц-1 худалдах, худалдаа авах 2022 оны 6 сарын 10-ны 1-3-268/22 дугаар гэрээний дагуу мөнгө шилжүүлсэн боловч 105,681,624.00 (нэг зуун таван сая зургаан зуун наян нэгэн мянга зургаан зуун хорин дөрөв) төгрөгийн сэлбэг материалыг хүлээн аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;" -д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гэрээний дагуу нийлүүлэх сэлбэг материалыг хүлээн аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал / Л.Эрхбаатар /, ерөнхий нягтлан бодогч / О.Энхбаяр / нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЭРЭЛ-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

*(Handwritten signature)*

Ц НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264200

Л.Албан Шалгалтын 2024/03/15/0055-00.0000

0001080637



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 № 526/А0150055

СМАГ-2024/9/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ Үүнд:

Тайлант хугацаанд 56 нэр төрлийн 366,573,170.00(гурван зуун жаран зургаан сая таван зуун далан гурван мянга нэг зуун дал) төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгсэл эхний үлдэгдэлтэй байхад нэмж бэлтгэн, тайлант хугацаанд зарцуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцоогүй тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 "Үр ашиггүй удаан хадгалах шаардлагагүйгээр бараа материал бэлтгэх" гэж заасантай нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 195 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хэрэгцээ шаардлагад үндэслэн бараа материал бэлтгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Л Эрхбаатар /, ерөнхий нягтлан бодогч /О Энхбаяр / нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  
АУДИТЫН МЭНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛЭН-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

*(Handwritten signature)*

Ц НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Д ТОВУУДОРЖ